

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/139/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Гантулга Утас: 70432545 цахим хаяг: Gantulga.TS@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	10
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	Error! Bookmark not defined.
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	15
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	16

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/109
танай _____ -ны № _____ -т

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БААТАРСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хууль тогтоомжид нийцүүлсэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай, ил тод, хүртээмжтэй хүргэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын Аудитын гол асуудал

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, шатахууны болон жолоочийн тооцоо бодоогүй, жолоочийн замын хуудас бичигдээгүй шатахуун зарлагадсан, хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй о өртөгтэй их хэмжээний хөрөнгө тайланд тусгагдан олон жил болсон зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д

021020209

"Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,385,841.00</u>	<u>47,537,497.00</u>
33	АВЛАГА	17,421,713.00	17,076,529.00
335	Бусад авлага	17,421,713.00	17,076,529.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	15,051,589.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	17,421,713.00	2,024,940.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,964,128.00	30,460,968.00
354	Хангамжийн материал	25,964,128.00	30,460,968.00
35410	Бичиг хэргийн материал	585,200.00	452,400.00
35420	Аж ахуйн материал	15,174,928.00	18,771,668.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,032,900.00
35470	Бусад хангамжийн материал	10,204,000.00	10,204,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,968,090,457.48</u>	<u>3,556,209,081.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,968,090,457.48	3,556,209,081.55
392	Биет хөрөнгө	1,964,090,457.48	3,552,209,081.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,714,769,625.00	2,056,360,494.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-514,485,056.30	-581,370,663.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	101,562,460.00	101,562,460.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,217,214.12	-51,894,707.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,723,516.00	164,260,003.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,623,216.17	-97,924,320.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,789,135.00	63,267,935.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,083,716.99	-42,447,392.75
39209	Зам, гүүрийн байгууламж	606,271,235.00	1,953,232,746.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-30,560,059.94	-91,781,221.79
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	77,831,000.00	77,831,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,081,850.00	1,081,850.00
39217	Ном	30,900.00	30,900.00
393	Биет бус хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
39301	Программ хангамж	2,443,700.00	2,443,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,443,700.00	-2,443,700.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,011,476,298.48</u>	<u>3,603,746,578.55</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,011,476,298.48</u>	<u>3,603,746,578.55</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,011,476,298.48	3,603,746,578.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,034,383,684.00	1,034,383,684.00
51101	Өмч: - төрийн	1,034,383,684.00	1,034,383,684.00
512	Хуримтлагдсан үр дүн	398,670,238.44	1,990,940,518.51
51210	Өмнөх үеийн үр дүн	398,670,238.44	398,670,238.44

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,592,270,280.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	578,422,376.04	578,422,376.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,011,476,298.48	3,603,746,578.55

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	542,713,649.00	2,245,133,393.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,371,760.00	1,733,638,867.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,371,760.00	1,733,638,867.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,371,760.00	1,733,638,867.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,980,000.00	3,880,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,550,000.00	1,729,758,867.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,287,372.00	511,494,526.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,703,559.00	134,005,099.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	3,842,640.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	98,901,838.35
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	31,260,621.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	335,202,600.00	369,219,427.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,202,600.00	369,219,427.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	16,211,800.00	8,270,000.00
1330	Төсвийн захирагчдаас	16,211,800.00	8,270,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	610,727,246.84	652,863,113.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,727,246.84	580,561,014.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	579,752,701.84	570,541,645.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,267,278.00	235,785,656.11
210101	Үндсэн цалин	203,267,278.00	235,785,656.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,541,852.00	29,423,195.09
210201	Тэтгэврийн даатгал	25,541,852.00	29,423,195.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,412,099.00	34,745,560.00
210301	Гэрэл, цахилгаан	3,835,991.00	4,913,360.00
210302	Түлш, халаалт	17,756,508.00	23,012,600.00
210303	Цэвэр, бохир ус	6,819,600.00	6,819,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,684,688.00	32,981,426.00

210401	Бичиг хэрэг	4,084,900.00	3,353,330.00
210402	Тээвэр, шатахуун	27,227,991.00	27,127,562.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,371,797.00	2,500,534.00
2105	Нормативт зардал	101,450.00	30,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	101,450.00	30,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,230,000.00	25,907,510.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	55,000.00
210604	Урсгал засвар	1,230,000.00	25,852,510.00
2107	Томилолт, зочны зардал	9,490,000.00	2,586,640.00
210702	Дотоод албан томилолт	9,490,000.00	2,586,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,557,072.00	16,120,155.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,761,572.00	14,883,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,500.00	216,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	251,468,262.84	192,961,502.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,339,248.00	36,512,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	223,129,014.84	156,449,042.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,974,545.00	10,019,369.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,272,495.00	10,019,369.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,272,495.00	10,019,369.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	72,302,098.35
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	72,302,098.35
220001	Барилга байгууламж	00.00	57,398,974.35
222001	Тоног төхөөрөмж	00.00	4,210,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	10,693,124.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-68,013,597.84	1,592,270,280.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-69,680,264.56	1,592,270,280.07

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	427,109,132.00	530,771,299.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,821,760.00	3,880,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,821,760.00	3,880,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,821,760.00	3,880,000.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,980,000.00	3,880,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	419,287,372.00	526,891,299.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,703,559.00	134,005,099.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	3,842,640.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	98,901,838.35
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	31,260,621.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,414,400.00	392,886,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,202,600.00	384,616,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	16,211,800.00	8,270,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	385,631,132.00	443,300,401.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,631,132.00	443,300,401.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,586,137.00	418,229,442.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,749,912.00	233,735,401.20
210101	Үндсэн цалин	129,551,912.00	156,546,998.87
210102	Нэмэгдэл	36,738,000.00	44,678,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,460,000.00	32,509,602.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,059,218.00	31,533,750.00
210201	Тэтгэврийн даатгал	27,059,218.00	31,533,750.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,336,849.00	34,745,560.00
210301	Гэрэл, цахилгаан	3,829,391.00	4,913,360.00
210302	Түлш, халаалт	16,687,858.00	23,012,600.00
210303	Цэвэр, бохир ус	6,819,600.00	6,819,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,642,336.00	30,875,226.00
210401	Бичиг хэрэг	3,620,398.00	3,863,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,639,141.00	24,324,962.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,382,797.00	2,687,264.00
2105	Нормативт зардал	1,172,000.00	366,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,172,000.00	366,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,549,200.00	26,532,510.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	181,000.00	180,000.00
210604	Урсгал засвар	1,868,200.00	26,352,510.00
2107	Томилолт, зочны зардал	9,490,000.00	2,586,640.00
210702	Дотоод албан томилолт	9,490,000.00	2,586,640.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,346,312.00	20,735,355.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,550,812.00	17,434,030.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	2,344,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,500.00	216,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,240,310.00	37,119,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,240,310.00	37,119,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,044,995.00	25,070,958.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,272,495.00	25,070,958.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,272,495.00	25,070,958.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	41,478,000.00	87,470,898.35
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,478,000.00	87,470,898.35
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,478,000.00	87,470,898.35
2200	Дотоод эх үүсвэрээр	41,478,000.00	87,470,898.35
220001	Барилга байгууламж	34,478,000.00	57,398,974.35
222001	Тоног төхөөрөмж	7,000,000.00	11,760,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	18,311,924.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-41,478,000.00	-87,470,898.35

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,383,684.00	578,422,376.04	398,670,238.44	2,011,476,298.48
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,383,684.00	578,422,376.04	398,670,238.44	2,011,476,298.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,383,684.00	578,422,376.04	398,670,238.44	2,011,476,298.48
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,592,270,280.07	1,592,270,280.07
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,034,383,684.00	578,422,376.04	1,990,940,518.51	3,603,746,578.55

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	377,310,700.00	386746830.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,310,700.00	367,878,030.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,090,700.00	367,878,030.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,467,000.00	233,517,701.20
210101	Үндсэн цалин	156,329,300.00	156,329,298.87
210102	Нэмэгдэл	44,678,800.00	44,678,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	32,458,900.00	32,509,602.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,518,200.00	31,518,200.00
210201	Тэтгэврийн даатгал	22,179,300.00	31,518,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,108,300.00	34,745,560.00
210301	Гэрэл, цахилгаан	4,275,700.00	4,913,360.00
210302	Түлш, халаалт	23,012,600.00	23,012,600.00
210303	Цэвэр, бохир ус	6,820,000.00	6,819,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,250,800.00	27,579,444.00
210401	Бичиг хэрэг	3,148,100.00	3,463,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,687,700.00	21,429,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,415,000.00	2,687,264.00
2105	Нормативт зардал	402,000.00	366,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	366,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,468,600.00	780,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	180,000.00
210604	Урсгал засвар	2,268,600.00	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,637,600.00	2,210,000.00
210702	Дотоод албан томилолт	6,637,600.00	2,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,232,200.00	15,458,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,085,200.00	12,156,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	2,344,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	216,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26006000.00	21703000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,556,000.00	21,703,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	122,378,800.00	18,868,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	122,378,800.00	18,868,800.00

222001	Тоног төхөөрөмж	29,268,800.00	7,550,000.00
223001	Бусад хөрөнгө	36,548,000.00	11,318,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	499,689,500.00	495,668,038.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	495,889,500.00	386746830.20
132001	Орон нутгийн төсвөөс	495,889,500.00	374596830,20
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		82700000.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,800,000.00	3,880,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,800,000.00	3,880,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13
620003	Үйлчлэх ажилтан	6	6

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	134,005,099.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	134,005,099.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,351,412.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,700.00
210101	Үндсэн цалин	217,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,550.00
210201	Тэтгэврийн даатгал	15,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,295,782.00
210401	Бичиг хэрэг	400,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,895,782.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,752,510.00
210604	Урсгал засвар	25,752,510.00
2107	Томилолт, зочны зардал	376,640.00
210702	Дотоод албан томилолт	376,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,277,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,277,230.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15416000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,416,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,051,589.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	15,051,589.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,602,098.35
220001	Барилга байгууламж	57,398,974.35
222001	Тоног төхөөрөмж	4,210,000.00
223001	Бусад хөрөнгө	6,993,124.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	134005099.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,005,099.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,842,640.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,901,838.35
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,260,621.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Д.Баатарсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын анхан шатны баримтын бүрдэл, авлага барагдуулах талаар менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын “Иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах” гэсэн эрхэм зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Алтай сумын Засаг даргын Тамгын газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 443717.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4437.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 652863.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6528.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1592270.3 мянган төгрөгөөр буюу 55.3 хувиар байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	17421.7	17076.5	345.2
БАРАА МАТЕРИАЛ	25964.1	30460.9	4496.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1968090.4	3556209.1	1588118.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2011476.3	3603746.6	1592270.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0.00	(0)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2011476.3	3603746.6	1592270.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2011476.3	3603746.6	1592270.3

Оны эхэнд 17421,7 мянган төгрөгийн авлага байснаас 15396,7 төгрөгийн авлага барагдуулж, тайлант онд нэмэлт дансны татан төвлөрүүлсний авлага 15051,5 мянган төгрөг, хувь хүмүүстэй холбоотой 2094.0 төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30460.9 мянган төгрөг болж 4496.8 төгрөгөөр өссөн нь тайланд онд ковид 19 холбогдуулан ариутгалын бодис болон онцгой байдлын хүнс, шатахуун нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1968094.4 мянган төгрөг, оны эцэст мянган төгрөг болж 158118.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд улсын төсөв болон ОНХСангаар хийгдсэн 43536.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1160512.7 мянган төгрөгийн бодончийн гүүр, 12478.8 төгрөгийн тавилга эд хогшил, 341590.8 төгрөгийн барилга байгууламж барьсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 42135.9 мянган төгрөг буюу 6.9 хувиар өссөн нь цалин, шимтгэлийн зардал 36399.7 мянган төгрөг буюу 15.9 хувь, тогтмол зардал 6333.5 мянган төгрөг буюу 22,3 хувиар өссөн. бараа үйлчилгээний бусад зардал 58506.8 мянган төгрөг буюу 23,3 хувь хангамж бараа материалын зардал 1703.3 мянган төгрөг буюу 4.9 хувь

нормативд зардал нь 71,4 мянган төгрөг буюу 70,3 хувь, томилолт 6903.4 төгрөг 72.7 хувиар буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 384616.2 мянган төгрөгөөр нийт зардлыг 384616.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлан онд орон нутгийн 367878.3 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн сангаас 82700.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3880.0 мянган төгрөг төвлөрүүлж нийт 386746.8 мянган төгрөг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 384616.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 10019.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар аймгийн засаг даргын тамгын газраас 134005.1 мянган төгрөг төвлөрүүлж 2895.8 мянган төгрөгийг тарваган тахлын болон бусад бензин зардалд, тоног төхөөрөмжид 4210.0 ажилчдын цалин хөлсөнд 233.2 мянган төгрөг, барилга байгууламж зардалд 57398.9 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардалд 6993.1 мянган төгрөг, бусад зардал 20639,2 мянган төгрөг, томилолтын зардал 376,6 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 400,0 мянган төгрөг, соёлын төвийн дээврийн засварын зардалд 25752.5 төгрөг нийт 118953,5 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, 6 мэдээллийг мэдээлээгүй байна. Тухайлбал шилэн дансны нэгдсэн сайтаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, байгууллагын батлагдсан төсөв, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмжийн хэрэгжилт 30 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 71205.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 69180.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах 1

албан шаардлага , 2024.9 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илэрсэнгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 71205.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 69180.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага бичиж хүргүүлээ.

1. Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй, жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагадсан , 97 нэр төрлийн 42053.3 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг ашиглаж байгаа, 38 нэр төрлийн 9914.6 мянган төгрөгийн хөрөнгө цаашид ашиглагдах боломжгүй байгааг байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн зэрэг зөрчил нь *Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдээгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" хуулийн заалт, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансны нэгдсэн сайтаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, байгууллагын батлагдсан төсөв, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй байгаа нь *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ". 8 дугаар зүйлийн 8.1, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтууд Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд ЗДТГ-ын харилцахаар гарсан гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил илэрлээ. Тухайлбал: Томилолт, тендер, гэрээгээр гүйцэтгэсэн ажил, олгосон урьдчилгаа, шатахууны зардал гэх мэт. Энэ нь Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2 Өгсөн зөвлөмж нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7-дахь заалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Авлагатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Хариуцах эзэн холбогдогч тодорхой бус хувь хүмүүстэй холбоотой 2024.9 мянган төгрөгийн авлага үүсэж, барагдахгүй байгаагаас насажсан авлагын ангилалд орж байгаа нь 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Эрсдэл: Хөрөнгийн үр өгөөж буурах

2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2021			ХОА-2021/139/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтай сумын Засаг даргын Тамгын газар		Мянган төгрөгөөр		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
			Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Нэр	Албан тушаал
	1	2	3	4	5

1	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Баатарсүрэн С.Ариунтунгалаг
2	Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй, жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагадсан ,хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй, элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглагдах боломжгүй хөрөнгө тайланд тусгагдан өдий хүрсэн.	69180.1	Албан шаардлага		
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	0	Зөвлөмж өгөх		
4	Хариуцах эзэн холбогдогч тодорхой бус хувь хүмүүстэй холбоотой авлага үүсгэсэн.	2024.9	Зөвлөмж өгөх		
Дүн		71205.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР